



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/215

Булган сум

**Шууд худалдан авах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Стандарт, хэмжил зүйн хэлтсийн лабораторийн этолан тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчээр "Монбио фарм" ХХК-тай 10 000 000 (Арван сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Монбио фарм" ХХК-ийн захирал (Б.Ундармаа)-д даалгасугай.

4.Тус барааг хууль, журам, гэрээний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010174